

9
10A0005

 БУЛГАН СУМЫН “БӨГТӨР ХАР”-ЫН РАШААНЫГ
 ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2019.02.19



Хэрлэн сум

№	Хийгдэх ажлууд	Тавигдах шаардлага
1	“Бөгтөр хар”-ийн рашааны эхийг хашиж хамгаалах	Булгийн эхийг хүн, малын хөлд бохирдохоос урьдчилан сэргийлж хамгаалалтын хашаа барина. Хамгаалалтын хашаа нь 20х30 метрийн харьцаатай 100 метр урт, 1.2 метр өндөртэй, сараалж хоорондын зай нь 15 см-ээс ихгүй, шонг 10 см-ээс багагүй диаметр төмөр трубагаар гагнаж хийнэ. Шонг газарт 0.4 м гүн бетон цементлэн суулгана.
2	Суврагыг тойруулан хамгаалалтын хашаа барина.	Суврагыг мал, амьтнаас хамгаалсан 30х30 метрийн харьцаатай 120 метр урт 1.2 метр өндөртэй, сараалж хоорондын зай нь 15 см-ээс ихгүй, шонг 10 см-ээс багагүй диаметр төмөр трубагаар гагнаж хийнэ. Шонг газарт 0.4 м гүн цементлэн суулгана.
3	Сүүдрэвч, ширээ, сандал	<p>Суврагын баруун талд 2 ширхэг сүүдрэвч хийнэ.</p> <p>-Сүүдрэвч нь 2.5 х 2.5м хэмжээтэй 1,8 метр өндөртэй байна.</p> <p>-Сүүдрэвчийг бат бөх төмрөөр хийж, газарт 0.4 м гүн цементлэн суулгана.</p> <p>-Сүүдрэвчийн ширээг 1.5 х 0.8м харьцаатай төмрөөр хийж, газарт хөдөлгөөнгүй цементлэн суулгана.</p> <p>-Сүүдрэвчинд 3м урттай, 0.4м өргөнтэй 2 ширхэг төмөр сандал байна.</p> <p>-Сүүдрэвч, сандал, ширээг зориулалтын төмрийн будгаар будна.</p> <p>-Сүүдрэвчийн дээвэр нь налуу хэлбэртэй байна.</p> <p>-Сүүдрэвч, ширээ, сандал нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан байна.</p>
4	Машины зогсоол	<p>-Авто зогсоолын замын тэмдэг “Техникийн ерөнхий шаардлага “MNS 4597 : 2013 стандарт” хангасан байх ба байршуулахдаа хөлийг 0,4 метрийн гүнд цементлэн хийнэ.</p> <p>-Зогсоолын хөндлөн хаалт нь 9 м урт, 1 м өндөр хөлтэй байна. Хөлийг газарт 0.4 м гүн суулган цементлэн бэхэлнэ.</p> <p>-Хаалт нь 2м тутамд хөлтэй байна.</p>


		-Хаалтыг 10 см диаметртэй шинэ төмрөөр хийж, улаан цагаан өнгийн гэрэл ойлгогчтой төмрийн будгаар алаглуулж будна.
5	Мэдээллийн самбар 2 ширхэг	<p>Рашааны ордын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэм, хог хаягдал, галын санамж байрлуулах мэдээллийн 3 ширхэг самбар хийнэ.</p> <p>- Самбарын хүрээг 20x40 мм тэгш өнцөгт төмрөөр гагнан хийж, 1x1 мм хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр битүүлж гагнаж бэхэлнэ.</p> <p>-Самбар нь 2 тулгуур багантай байна. Багана нь 2.5 метрийн урттай 80x80 мм квадрат төмрөөр хийж, самбарын хүрээтэй гагнаж бэхэлнэ.</p> <p>-Самбарын тулгуур баганыг газарт 50 см гүн суулгаж, цементлэн бэхэлнэ. Тулгуур баганы газарт суух хэсэгт хөндлөвч төмөр гагнасан байна.</p> <p>-Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна.</p> <p>-Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч бэлтгэн байрлуулна.</p>

“БӨГТӨР ХАР”-ЫН РАШААНЫГ ТОХИЖУУЛАХ ЗУРАГЛАЛ

Байршил: Сумын төвөөс зүүн тийш 35 км-т Мөнх уулын зүүн хойно Хэрлэн голын эрэг дээр байрладаг.



БӨГТӨР ХАРЫН РАШААНЫГ ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ХАШААЖУУЛАЛТЫН ЗУРАГ



Сүүдрэвчний хэмжээс

